131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,075.71
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,015.62
131106	Төсвийн урамшуулал	
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга И.Дөрвөтхан танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд сумын Засаг даргын сангуудын хариуцсан албан тушаалын чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр засгийн болон сумын бодлогын хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах үр дүнг шударгаар тооцох замаар төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлэх улмаар орон нутгийн хөгжлийг тэтгэх чадварлаг захиргааны байгууллагыг төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2021 онд Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад шалгалт хийгдээгүй байна.

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 3,422.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 34.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 23.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	67.2	219.8	152.6	
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>67.2</b>	<b>219.8</b>	<b>152.6</b>	

*Эх сурвалж: Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 219.8 сая төгрөг болж 152.6 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 219.8 сая төгрөгийн 122.0 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 69.8 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 28.0 сая төгрөг нь орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил гараагүй байна.*

### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 323.7 сая, эцсийн үлдэгдэл 265.9 сая төгрөг болж, 57.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	7.9	5.7	-2.2
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага	7.0	26.6	19.6
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	25.8	10.3	-15.5
Зээлийн авлага	283.0	223.3	-59.7
<b>Дүн</b>	<b>323.7</b>	<b>265.9</b>	<b>-57.7</b>

*Эх сурвалж: Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 84 хувийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 16 хувийг төсөвт байгууллагын авлага эзэлж байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл 223.3 сая төгрөг байгаа нь тайлант оны зээлийн эргэн төлөлтийн хэмжээгээр буурсан байна.

Татаас санхүүжилтийн авлага 26.6 сая төгрөг болж 19.6 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвийн Эрүүл мэндийн даатгалын сангаас авах Ковид-19 цар тахлын улаан бүсэд ажилласан ажилчдын урамшуулал болон бараа үйлчилгээний зардлын авлага байна.

Бусад авлагын үлдэгдэл 10.3 сая төгрөг болж 15.5 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн оны эхэнд байгаа үлдэгдэл буурсантай холбоотой байна. Тайлант оны эцэст ИТХурал 0.7 сая төгрөгийн, ЗДТГазар 2.1 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 0.8 сая төгрөгийн, 2 дугаар сургууль 0.2 сая төгрөгийн, 3 дугаар сургууль 4.9 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 3.9 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна.

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 237.8 сая, эцсийн үлдэгдэл 270.1 сая төгрөг болж, 32.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	12.3	16.9	4.6
Хангамжийн материал	224.7	252.5	27.8
Мал амьтад	0.7	0.7	
<b>Дүн</b>	<b>237.8</b>	<b>270.1</b>	<b>32.3</b>

*Эх сурвалж: Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэл 270.1 сая төгрөг болж 32.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд сумын төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 356.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 18.7 сая төгрөгийн материалыг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, үйл ажиллагаандаа 334.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 8.2 сая төгрөгийн материалыг акталсантай холбоотой байна.

Бараа материалын нийт үлдэгдлийн 2.0 сая төгрөг нь Засаг даргын тамгын газрын, 126.1 сая төгрөг нь Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн, 26.9 сая төгрөг нь 2 дугаар сургуулийн, 6.5 сая төгрөг нь 3 дугаар сургуулийн, 30.0 сая төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 75.9 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 2.6 сая төгрөг нь Соёлын төвийн үлдэгдэл байна.

#### Аудитын илрүүлэлт:

1.Засаг даргын тамгын газар 2.1 сая төгрөгийн тээвэр шатахууны зарцуулалтын баримтын бүрдэлт дутуу, нярвын бараа материалын зарцуулалтын тайлан, нягтлан бодогчийн гаргасан бараа материалын тайлангаас 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй, шатахууны зарцуулалтын жагсаалтад хэрэглэсэн албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулж баримтжуулаагүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

2.Хүүхдийн цэцэрлэгийн жилийн эцсийн бараа материалын тооллогын бүртгэлээр 7.9 сая төгрөгийн хүнсний материал тоологдсон боловч санхүүгийн тайланд 12.8 сая төгрөгийн үлдэгдэл байгаагаар тусгаж, үлдэгдлийг 4.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

Мөн санхүүгийн тайланд олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой 3.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй тайлагнаж, бараа материалын үлдэгдэлд байгаа зөрүү болон авлагатай холбоотой дээрх зөрчлийг арилгах талаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

3.Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль бараа материалын тодруулга тайлан, нярвын материалын тайлангийн орлого, зарлагын гүйлгээг тулган шалгахад хүнсний материалын орлого тодруулга тайланд 20.7 сая төгрөг, нярвын тайланд 16.3 сая төгрөг 4.4 сая төгрөгөөр дутуу, Хүнсний материалын зарлага тодруулга тайланд 22.6 сая төгрөг, нярвын тайланд 15.8 сая төгрөг 6.8 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.

Харилцах данснаас хоолны зардалд шилжүүлсэн зарлагын гүйлгээг нярвын тайлангийн орлогын падаанаар тулгаж үзэхэд хүнсний материалын орлогыг 4.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасан. Аж ахуйн материалын тайлангийн анхан шатны баримтын хөтлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна. Дээрх зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлэв.

#### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,449.0 сая, эцсийн үлдэгдэл 4,610.2 сая төгрөг болж, 161.2 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4327.0	4486.6	159.6
Биет бус хөрөнгө	122.0	123.5	1.5
<b>Дүн</b>	<b>4449.0</b>	<b>4610.2</b>	<b>161.2</b>

Эх сурвалж: Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 36.3 сая, үнэ төлбөргүй хандиваар хүлээн авсан 340.7 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 54.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, акталсан байна. Дуусаагүй барилга дансанд

хөрөнгө бүртгэгдээгүй байна. Тайланд үндсэн хөрөнгөнд нийтдээ 203.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 111.9 сая, эцсийн үлдэгдэл 55.1 сая төгрөг болж, 56.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	38.2	10.3	-27.8	18.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.02	0.02	0	
Байгууллагад төлөх өглөг	70.3	41.2	-29.1	74.8
Хувь хүмүүст төлөх өглөг	3.4	3.6	-0.2	6.5
<b>Нийт дүн</b>	<b>111.9</b>	<b>55.1</b>	<b>-56.8</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн 18.7 хувийг ажилчидтай холбогдсон өглөг, 74.8 хувийг байгууллагад төлөх өглөг, 6.5 хувийн хувь хүмүүст төлөх өглөг эзэлж байна. ЗДТГазар 2.3 сая төгрөгийн, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 0.9 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 0.3 сая төгрөгийн, 3 дугаар сургууль 5.0 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 22.9 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 1.2 сая төгрөгийн, Соёлын төв 0.1 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сан 22.3 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,965.7 сая, эцсийн үлдэгдэл 5,311.0 сая төгрөг болж, 345.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6 Засгийн хувь оролцоо /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1669.8	1669.8	0	31.4
Хуримтлагдсан үр дүн	921.0	1281.0	360.0	24.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2374.9	2360.2	-14.7	44.5
<b>Дүн</b>	<b>4965.7</b>	<b>5311.0</b>	<b>345.3</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5311.0 сая төгрөг болж 345.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс оны эцэст 2360.2 сая төгрөг болж 14.7 сая төгрөгөөр буурсан нь сумын Засаг даргын тамгын газрын актлагдсан хөрөнгөтэй холбоотой гарсан өөрчлөлт байна. Хуримтлагдсан үр дүн 1281.0 сая төгрөг болж 360.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.10. Орлогын данс

Баяннуур сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн татварын орлогоос 86.5 сая төгрөгийн орлого оруулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 59.7 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 27.2 сая төгрөгийн, тусгай зориулалтын шилжүүлгээс 3116.8 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 4.6 сая төгрөгийн, орон нутгаас 740.9 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 146.4 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үнэ

төлбөргүйгээр 358.5 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч нийтдээ 4540.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 4540.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 181.9 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан татварын болон татварын бус орлоготой холбоотой байна.

### **3.5.11 Зардлын данс**

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 4085.7 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 44.8 сая төгрөгөөр буюу 10 хувиар буурсан байна.

Нийт зардлын 97 хувь нь бараа үйлчилгээний зардал, 3 хувь нь урсгал шилжүүлэг байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглалт болон урсгал шилжүүлгийн зардал 13.2-521.4 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зардлын данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

*1. Эрүүл мэндийн төв 37.8 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.*

*2.Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль дотуур байрны хүүхдийн хоолонд Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг 545.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн төсвөөс хууль бус зарлага гаргасан.*

*Хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, тогтмол зардалд, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжын зардал, бараа үйлчилгээний бусад зардалд нийт 3.4 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.*

*3.Эрүүл мэндийн төв Шүүхийн Эрүүл мэндийн даатгалын сангаас 2019 онд олгосон өдрийн эмчилгээний санхүүжилтийг буцаан төлүүлэх тухай захирамжийн дагуу нэмэлт санхүүжилтийн төсвөөс 16.2 сая төгрөгийг төлж үр ашиггүй зардал гаргасан байна.*

Мөн цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал, багаж, техник, хэрэгслийн зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлын нийт 37.7 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, Харилцах данснаас эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл материалд шилжүүлсэн зарлагын гүйлгээг нярвын бараа материалын тайлангийн орлоготой тулгаж үзэхэд эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл материалын орлогыг 4.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна.

### **3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Баяннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 4062.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3928.7 сая төгрөгийг урсгал зардалд, 134.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 3116.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 681.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 134.1 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 37.3

сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 65.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 28.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### Төсвийн гүйцэтгэл

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 4034.2 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 3110.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 697.7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 4.7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 134.1 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 59.7 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 27.2 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн 59.7 сая төгрөгийн орлогын 57.7 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3877.2 сая төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь дутуу авсан санхүүжилт, тасарсан орлоготой холбоотой байна.

#### Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Баяннуур сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 70.5 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор Баяннуур сумын төсвийн орлогыг 70.5 сая төгрөгөөр баталж өөрчлөлт оруулаагүй байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 21 дүгээр хуралдааны тогтоолоор 2021 орлогын төлөвлөгөөг 70.5 сая төгрөгөөр буюу хэвээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 86.5 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 15.9 сая төгрөгөөр буюу 22.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

<i>Хүснэгт №7 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>				<i>/сая төгрөг/</i>	
<u>Үзүүлэлт</u>	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	<u>Өсөлт/+/</u> <u>бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх</u> <u>хувь</u>	
I.Татварын орлого	69.2	76.4	7.2	88.3	
II.Татварын бус орлого	1.3	10.0	8.7	11.7	
<b>Нийт дүн</b>	<b>70.5</b>	<b>86.5</b>	<b>15.9</b>	<b>100.0</b>	

Хөрөнгийн албан татвар 8.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 1.3 сая төгрөгөөр, газрын төлбөр 2.2 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд хөрөнгийн орлогын албан татвар 8.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 1.3 сая төгрөгөөр, газрын төлбөр 2.2 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.6 сая төгрөгөөр тасарч, хөрөнгө борлуулсны албан татвар 4.0 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 8.7 сая төгрөгөөр тус тус давж биелэгдсэн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 67.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 86.5 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 27.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

#### Хүснэгт №8 Төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

*/сая төгрөг/*

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	75.6	71.8	3.8
2	Сумын ЗДТГ	316.1	316.1	
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	1846.3	1838.4	7.8
4	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	288.8	284.2	4.6
5	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	179.5	178.4	1.1
7	Хүүхдийн цэцэрлэг	448.8	448.2	0.6
9	Соёлын төв	85.5	85.5	
10	Эрүүл мэндийн төв	623.1	590.5	32.6
11	ОНХСан	134.1	161.3	-27.2
12	СХС	65.0	59.7	5.3
	<b>Нийт дүн</b>	<b>4062.9</b>	<b>4034.2</b>	<b>-18.1</b>

#### Аудитын илрүүлэлт:

1. Төсөвт байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийг ЗДТГ 3.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй тул төсвийн шууд захирагч нарт тус тус албан шаардлага хүргүүлсэн.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын төсөвт байгууллагууд тусламж дээд шатны төсвийн захирагчаас 124.1 сая төгрөгийн, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 21.3 сая төгрөгийн, төсвийн урамшуулал 1.0 сая төгрөгийн, нийт 146.4 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 19.4 сая, хангамж бараа материалын зардалд 14.5сая, нормативт зардалд 43.1 сая, эд хогшил урсгал засварын зардалд 7.5 сая, томилолтын зардалд 0.5 сая, бараа үйлчилгээний бусад зардал 10.8 сая, урсгал шилжүүлэгт 42.2 сая, хөрөнгийн зардалд 8.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна

#### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст Баяннуур сумын Засаг даргын 2021 оны 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус ТТЗ-ийн багцад хамаарах 10 байгууллагыг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

#### Аудитын илрүүлэлт:

1. Соёлын төв нийт 85.5 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 24.5 сая мянган төгрөгийн 3 мэдээлэл, бусад мэдээллээс 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар энэ зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлсэн.

2. Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Эрүүл мэндийн төв шилэн дансны 11 мэдээллийг хугацаа хоцроож, өр, авлага үүсгэсэн нийт 49.5 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй шилэн дансны мэдээллийг мэдээлсэн байдал 85.0 хувьтай хэрэгжсэн тул зөвлөмж хүргүүлсэн.

3. Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нийт 257.2 сая төгрөгийн 119 мэдээллийг ил тод мэдээлэхээс 11 мэдээллийг хугацаа хоцроож, хэрэгжилт 90.0 хувьтай байна.

4. Эрүүл мэндийн төв нийт 651.5 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 651.5 сая төгрөгийн 106 мэдээллийг хугацаандаа байршуулж, 11 мэдээллийг хугацаа хоцроож, өр, авлага үүсгэсэн 2 мэдээллийг байршуулаагүй байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 85.0 хувьтай хэрэгжсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил гараагүй байна.

Хүснэгт: №9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж							
<b>Нийт</b>							

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6

байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 2 дугаар сургууль, 3 дугаар сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт, Хүүхдийн цэцэрлэгт “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга хийгдээгүй байна.

### **Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлантай холбоотой алдаа зөрчил илрээгүй, залруулга хийгдээгүй, акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 389.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс сумын төсөвт байгууллагын дүнгээр 39.0 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 97.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлж, 253.4 сая төгрөгийн зөрчлийг залруулсан байна.

Хүснэгт №10: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	2	6.2					2	6.3		
2	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	1								1	
3	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	3	340.7	1	253.4					2	87.3
4	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	1	9.9							1	9.9
5	Хүүхдийн цэцэрлэг	1	8.3					1	8.3		
6	Соёлын төв	1	24.5					1	24.5		
<b>Нийт дүн</b>		<b>9</b>	<b>389.6</b>	<b>1</b>	<b>253.4</b>			<b>4</b>	<b>39.0</b>	<b>4</b>	<b>97.2</b>

### **3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

#### **1. Албан тушаалын чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой асуудал:**

##### **1.1. Илрүүлэлт:**

Сумын Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг сангуудыг хариуцаж байгаа мэргэжилтэн нар зурж, тайлан баланс гаргаж ирүүлсэн байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын албан тушаалын 2 дугаар зорилтын 12, 3 дугаар зорилтын 1-д заасныг зөрчсөн байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах зөрчлийг арилгаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяннуур сумын ТТЗСНТайлан										